

“Анод банк” ХХК-ийн нийтэд санал болгон
гаргах хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл болон “Анод банк” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2007 оны 06 тоот, 2008 оны 19 тоот тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Анод банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 39 418 531 ширхэг энгийн хувьцааг Хорооны нийтэд санал болгон гаргах үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-д, Хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р. Содхүү/-д., Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд бүртгэхийг “Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Нийтэд санал болгон худалдах 19 315 080 ширхэг хувьцааг нийтэд санал болгон гаргахад дор дурдсан хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай:

а/ 2008 оны 5 дугаар сарын 2-ны өдрөөс 5 дугаар сарын 18-ны өдрийг дуустал хугацаанд нийтэд санал болгон гаргах хувьцаа, түүний танилцуулгыг нийтэд сурталчилах;

б/ 5 дугаар сарын 19-ний өдрөөс 5 дугаар сарын 23-ны өдрийг дуустал хугацаанд хувьцааны захиалгыг авахаар гэрээ байгуулсан брокер, дилерийн компаниар дамжуулан захиалгыг авах;

в/ 5 дугаар сарын 24-ний өдрөөс 5 дугаар сарын 26-ны өдөр хувьцаа худалдах үнийг тогтоож, ирүүлсэн захиалгын гэрээ, тэдгээрийн жагсаалт, захиалгын дагуу төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан, хувьцаа худалдах үнийг тогтоосон болон захиалгын дагуу хувьцааг хувь тэнцүүлэн хуваарилсан тооцоолол, тэдгээрийн үндэслэл, сурталчилгаа явуулсан тайлан зэрэг холбогдох бичиг баримтыг Хороонд ирүүлэх;

г/ Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хувьцааны арилжаа, төлбөр тооцоо, бүртгэлийг Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан хийж гүйцэтгүүлэх.

3. Энэхүү тогтоолын 2-ын в-д заасан хувьцаа худалдах үнийг ирсэн нийт захиалгын дагуу тодорхойлогдох нэгж хувьцааны дундаж үнэ, нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон нийт хөрөнгийг бүрдүүлэх боломжит үнэ, аль болох олон захиалагчийн захиалгыг биелүүлэх боломжит үнийг харгалзан тогтоохыг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын 3-т заасан үнийг тогтоохдоо захиалгын гэрээний маягтыг үнэн зөвөөр бүрэн бөглөж, тухайн захиалгын дагуу худалдах авах хувьцааны төлбөрийг тусгайлан нээсэн дансанд байршуулсан захиалгын саналыг баримтлахыг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай.

5. Хувьцааг хувь тэнцүүлэн хуваарилахдаа энэхүү тогтоолын 3-т заасан зарчмын дагуу тогтоосон хувьцаа худалдах үнийг баримтлахыг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай.

6. Үнэт цаас гаргагчийн нэр дээр тусгайлсан данс нээх, захиалгын дагуу холбогдох хөрөнгийг тухайн дансанд байршуулж ажиллахыг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/, “Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандуламд/-д үүрэг болгосугай.

7. Үнэт цаас гаргагч нь энэхүү тогтоолын 6-д заасан дансанд байршсан хөрөнгийн хувьд үнэт цаас гаргагч өмчлөх эрх эрх эдлэхгүй болохыг тогтоосугай.

8. Үнэт цаас, түүний танилцуулгыг нийтэд сурталчлахдаа хувьцааны үнэ, ханшны талаар аливаа амлалт өгөхгүй байх, бусад үнэт цаасны үнэ, ханшийн өөрчлөлттэй харьцуулалт хийхгүй байх, олон нийтийг бодитой үнэн зөв мэдээллээр хангаж ажиллахыг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай.

9. Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хувьцааны арилжаа, төлбөр тооцоо, бүртгэлийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р. Содхүү/-д, “Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

10. Үнэт цаасны анхдагч арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан энэ тогтоолын 7-д заасан данснаас биелээгүй захиалгын болон үлдэгдэл хөрөнгийг холбогдох захиалагчийн дансанд бүрэн буцаан байршуулахыг “Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандуламд/-д үүрэг болгосугай.

11. Энэ тогтоолын 10-д заасан ажлыг гүйцэтгэж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг Хороонд ирүүлэхийг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай.

12. Стратегийн хөрөнгө оруулагч болох БНСУ-ын “Шенан” /Shinhan bank/ банк, “Түшиг” ХХК-аас татан төвлөрүүлэх хөрөнгийг оролцуулан нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон 19 315 080 000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг бүрэн бүрдүүлэх боломжгүй болсон тохиолдолд хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг амжилтгүй болсонд тооцохыг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/-д анхааруулсугай.

13. Энэхүү тогтоолд заасны дагуу хувьцааг нийтэд санал болгон гаргах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд “Анод банк” ХХК-ийн нэр бүхий 14 хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хаалттай компанийн хувьцааг нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 20 103 451 ширхэг хувьцаа болгон хавсралтын дагуу хөрвүүлж өмчлөх эрхийг баталгаажуулах шийдвэр гаргахаар тогтсугай.

14. Энэхүү тогтоолд заасны дагуу хувьцааг нийтэд санал болгон гаргах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд стратеги хөрөнгө оруулагч болох БНСУ-ын “Шенан” /Shinhan bank/ банканд 4 898 770 ширхэг хувьцааг, “Түшиг” ХХК-д 4 898 770 ширхэг хувьцааг нэг бүрийг нь энэхүү тогтоолын 4-т заасан хувьцаа худалдах үнээс доошгүй үнээр тооцож тэргүүн ээлжинд багцлан худалдахыг зөвшөөрөх тухай шийдвэр гаргахаар тогтсугай.

15. Үнэт цаас гаргагч нь өөрийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцаагаа анхдагч зах зээлээс худалдан авах захиалга өгөх болон хувьцаагаа худалдан авахыг хориглосугай.

16. Энэхүү тогтоолын 3-т заасан хувьцаа худалдах үнийг тогтоохдоо стратеги хөрөнгө оруулагчаас ирүүлсэн захиалгыг бусад ирүүлсэн захиалгын нэгэн адил үзэж, тооцооллыг хийхийг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай.

17. “Анод банк” ХХК-ийн нэр бүхий 14 хувьцаа эзэмшигчдийн эзэмших 20 103 451 ширхэг хувьцааг үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа явагдах эхний өдрөөс эхлэн 6 сарын хугацаанд тусгаарлаж хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулахгүй байхыг “Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандуламд/-д үүрэг болгосугай.

18. Хувьцааг нийтэд санал болгон гаргах ажиллагааг тусгайлан комисс томилох замаар энэхүү тогтоолд заасны дагуу зохион байгуулахыг “Анод банк” ХХК /Л.Уламбаяр/-д үүрэг болгосугай.

19. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ